

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Газрын дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор Б.Должмаа

Аудитор П.Мөнх-Эрдэнэ

Аудитор Б.Нарангэрэл

2018 оны 06 дугаар сар

Уг тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.

Хаяг: Баянхонгор сум, Номгон

1-р баг, Төр захиргааны ордон 3-р давхар

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хавсралт судалгааны жагсаалт.....	2
Нийцлийн аудитын тайлан.....	3-5
Ерөнхий мэдээлэл.....	6-7
Нийцлийн аудитын дүн.....	8
НЭГ. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Төсвийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг баталсан байна.	
1.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөвгүй ажил баталдаг, зарим төсөл, арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт үндэслэлгүй байгааг харуулж байна.	8-9
1.2 Аймгийн ТЕЗ-ийн хүрээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн ОНӨГ-аас зохион байгуулах ажлын хэмжээнд гаргасан байна.	9-11
ХОЁР. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.	
2.1 Үнэлгээний хорооны гишүүнээр АЗ гэрчилгээгүй иргэдийг томилсон, техникийн тодорхойлолтыг зохих шаардлагын дагуу боловсруулаагүй, үнэлгээний хурлын тэмдэглэлд гишүүдийн гарын үсгийг бүрэн зураагүй зэргээр үнэлгээний хороо хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.	11-16
2.2 Зарим үнэлгээний хороо тендерийг зөв үнэлээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй зэргээр хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.	16-22
ГУРАВ. Аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланд захиалагч байгууллагуудын тайланг нэгтгэж гаргаагүй байна.	
3.1 Захиалагч байгууллагууд хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааны тайланг аймгийн ОНӨГ-т ирүүлээгүй байна.	22-24
3.2 Худалдан авах ажиллагаа бүрд архивын нэгж үүсгэн хадгалсан тендерийн хавтаст хэрэгт хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй байна.	24
Холбогдох байгууллагуудын санал.....	25-26
Аудитын дүгнэлт.....	27
Аудитын зөвлөмж.....	28-29
Тайлан баталгаажуулсан тушаал.....	30-31
Хавсралт №01 Аудитын түүврээр илэрсэн зөрчлийн судалгаа 2016 он.....	32-41
Хавсралт №02 Аудитын түүврээр илэрсэн зөрчлийн судалгаа 2017 он.....	42-58

Товчилсон Үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа

Хавсралт судалгааны жагсаалт

Хавсралт №1	Аудитын түүврээр илэрсэн зөрчлийн судалгаа 2016 он
Хавсралт №2	Аудитын түүврээр илэрсэн зөрчлийн судалгаа 2017 он

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн 1а/398 тоот албан бичгээр ирүүлсэн аудит хийлгэх захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, түүний үр дүнд аудит хийж, дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Тендерийн бэлтгэл ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?
- Гүйцэтгэгчийг зохих журмын дагуу сонгон шалгаруулсан уу?
- Худалдан авах ажиллагааг журмын дагуу тайлагнасан уу?

Аудитад аймгийн ОНӨГ-аас 2016, 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулж, аймгийн ЗДТГ, ХОХБТХ, ОНӨГ-ын хүрээнд аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журам болон нийцлийн аудитын удирдамж /АДБОУС 4000-4200/-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримтад хавсаргав.

Ингэхдээ холбогдох хууль, эрхийн актыг судлах, Сангийн яаманд хүргүүлсэн төлөвлөгөө, тайлан мэдээ болон бусад судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга, лавлагаа авах зэрэг аргуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид ТБОНӨХБАҮХАТ хууль гэх/;
- Барилгын тухай хууль;
- Сангийн сайдын 2012 оны 264-р тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
- Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”
- Сангийн сайдын 2015 оны 330 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”
- Сангийн сайдын 2013 оны 264 тоот тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх журам”
- Сангийн сайдын 2017 оны 234 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”
- Сангийн сайдын 2008 оны 249 тоот тушаалаар батлагдсан “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”
- Сангийн сайдын 2003 оны 39 тоот тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2012 оны 194 тоот тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”
- Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 115 тоот тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”
- Сангийн сайдын 2017 оны 32 тоот тушаалаар батлагдсан “Цахим тендер зохион байгуулах журам”
- Сангийн сайдын 2013 оны 84 тоот тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”

- Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт “ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”
- Сангийн сайдын 2007 оны “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”
- Дээрх хууль, журмуудтай нийцүүлэн гаргасан тендерийн жишиг баримтууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрд хяналт тавьж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл нар 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ХОХБТХ-ийн дарга, мэргэжилтэн, аймгийн ОНӨГ-ын мэргэжилтнүүдтэй аудитын “Төгсгөлийн уулзалт”-ыг зохион байгуулж, нийцлийн аудитаар илэрсэн зөрчил болон тайлангийн төсөлд туггагдсан асуудлуудын талаар харилцан санал солилцов.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 02 тоот захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны албыг дарга, 3 мэргэжилтэнтэй ажиллахаар анх байгуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоол, Баянхонгор аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/633 тоот захирамжаар дээрх албыг ОНӨГ болгон 10 орон тоотойгоор ажиллахаар баталж, бүтцийг тогтоож өгсөн байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 660 тоот захирамжаар 2016 онд 32 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Дээрх төлөвлөгөөнд 3 дугаар сард 22, 6 дугаар сард 19, 9 дүгээр сард 8, 11 дүгээр сард 5 бараа, ажил, үйлчилгээг нэмж тодотгож, нийт 86 нэр төрлийн 5,8 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг 2016 онд явуулахаар баталснаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4,0 тэрбум төгрөгийн 48, ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1,8 тэрбум төгрөгийн 38 төсөл арга хэмжээг баталсан байна.

2016 онд зохион байгуулахаар төлөвлөсөн 5,8 тэрбум төгрөгийн 86 худалдан авах ажиллагааг 100% зохион байгуулснаас 44,1 хувийг цахимаар зарласан бөгөөд үүнээс 3,4 тэрбум төгрөгийн 29 тендерийг нээлттэй, 2,0 тэрбум төгрөгийн 57 тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж, 0,4 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт гарчээ.

2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 5,0 тэрбум төгрөгийн 65, ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 4,4 тэрбум төгрөгийн 67, нийт 9,4 тэрбум төгрөгийн 132 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөг батлуулж ажиллажээ.

2017 онд аймгийн ОНӨГ-аас зохион байгуулахаар төлөвлөсөн 132 бараа, ажил, үйлчилгээний тендерээс 16 тендерийг цахимаар зарласан бөгөөд 5,8 тэрбум төгрөгийн 45 тендерийг нээлттэй, 3,0 тэрбум төгрөгийн 80 тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар, 0,06 тэрбум төгрөгийн 5 тендерт зөвлөх үйлчилгээний аргыг хэрэглэж, нийт 8,9 тэрбум төгрөгийн 130 тендерийг зохион байгуулж, 0,5 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна. Төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээнээс

2 ажилд тендер зарлах бэлтгэл шатандаа явж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, дараагийн онд шилжиж, төлөвлөгөөний биелэлт 98,4%-тай байна.

№	Тендер шалгаруулалтын журам /арга/	2016 он					2017 он				
		Батлагдсан нийт төсөв /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/	Хэмнэлт /сая.төг/	Тендер шалгаруулалтын тоо	Цахим тендер шалгаруулалтын тоо	Батлагдсан нийт төсөв /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/	Хэмнэлт /сая.төг/	Тендер шалгаруулалтын тоо	Цахим тендер шалгаруулалтын тоо
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	3,751.1	3,462.6	134.6	29	8	6,132.2	5,842.6	289.5	45	7
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын арга			-					-		
3	Харьцуулалтын арга	2,073.8	1,999.6	74.2	57	26	3,225.1	3,061.3	163.8	80	9
4	Шууд гэрээ байгуулах арга			-					-		
5	Шууд худалдан авалт			-					-		
6	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах журам			-			58.0	51.0	7.0	5	
7	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам										
	Дүн	5,824.9	5,462.2	208.8	86	34	9,415.3	8,954.9	460.3	130	16

Тус нийцлийн аудитыг түүврийн аргаар гүйцэтгэж 2016 онд зохион байгуулсан тендерийн 51,2% буюу 44 тендер, 2017 онд зохион байгуулсан тендерийн 54,6% буюу 71 тендер, нийт 115 тендер шалгаруулалтыг хамруулж шалгалаа.

Зохион байгуулсан худалдан авах ажиллагаанаас 2016 онд 1, 2017 онд 12 тендерт оролцогч Сангийн яаманд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн бөгөөд үүнээс 3 гомдолд үнэлгээний хороог зөв шийдвэр гаргасан гэж үзсэн, бусад 10 гомдолд үнэлгээний хорооны шийдвэрийг буруу гэж үзсэн учир тендерийг дахин зарласан байна.

Сангийн яамнаас Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2015 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 69 оноо буюу “Хангалттай”, 2016 оны хэрэгжилтийг 68 оноо буюу “Хангалттай”, 2017 оны хэрэгжилтийг 57 оноо буюу “Хангалттай” гэж тус тус үнэлжээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Төсвийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг баталсан байна.

1.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөвгүй ажил баталдаг, зарим төсөл, арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт үндэслэлгүй байгааг харуулж байна.

1.1.1 Аймгийн ХОХБТХ хөрөнгө оруулалтын төсвийн төсөөллийн судалгааг нэгтгэж гаргасан ба тухайн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн саналыг ТЭЗҮ, зураг төсвийн хуулбарын хамт харьяа яамдад хүргүүлсэн, ажлуудын зураг төсвийг аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн гэсэн тайлбарыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн бөгөөд аудитаар ямар ажлын ТЭЗҮ, зураг төсвийг тухайн үед байсныг тулган үзэх боломжгүй байна.

Аймгийн ОНӨГ-ын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдээс авсан тайлбарт "ТЭЗҮ, зураг төсөв, техникийн тодорхойлолт ирсэн даруйд нь худалдан авах ажиллагааг зарлаж зохион байгуулдаг, анхнаасаа захиалагч байгууллага техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын даалгавар зэргийг бэлэн болгосныхоо дараа төсөв хөрөнгөө шийдвэрлэх ёстой байтал эхлээд батлуулчихдаг, дараа нь төлөвлөгөөнд тусгасан хугацаанд тендерийг зохион байгуулах гэхээр зураг төсөв нь өөрчлөгдсөн байдаг тул эдгээрийг бэлэн болсны дараа тендерийг зарладаг" гэсэн тайлбаруудыг өгснөөс үзэхэд ТЭЗҮ, зураг төсвийг үндэслэж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахгүй байна гэж үзэхээр байна.

Энэ нь нөгөө талаас Сангийн яаманд хүргүүлсэн 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тендерээс 1946,0 сая төгрөгийн 4 тендер, 2017 оны төлөвлөсөн тендерээс 836,3 сая төгрөгийн 13 тендер санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас зохион байгуулаагүй нь дээрхийг нотолж байна.

ТЕЗ-ийн төсвийн төсөлд зураг, төсөвгүй, хуучирсан зураг төсөвтэй төсөл, арга хэмжээг шинээр эхлүүлэхээр төлөвлөж Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4¹-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

¹ "ТЕЗ ... өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах."

1. Бөмбөгөр сумын Спорт заалны барилгын төсөвт өртгийг 530,0 сая төгрөгөөр төлөвлөсөн байхад тендер зарлах үед зураг төсөв өөрчлөгдсөн шалтгаанаар 450,2 сая төгрөгөөр тендерийг зарласан;

2. Тээврийн товчооны үйлчилгээний газруудыг цэвэр бохирын шугамд холбох ажлыг 2014 оны зураг төсвөөр хийхээр төлөвлөж, 42,1 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч, төсвийн зөрүү гарч зураг төсөвт өөрчлөлт орж 79,9 сая төгрөг болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4² дэх заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1³ дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 3.7⁴-т заасныг зөрчиж байгаад цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлэв.

1.1.2 Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, тооцоолол судалгаа урьдчилж гаргадаг гэж байгаа боловч төлөвлөлтийн шатанд хийгдсэн судалгаа, баримтыг архивын нэгж болгон хадгалаагүй байна. Тайлант хугацааны дундуур захиалагч байгууллагуудаас ирүүлсэн тендер зохион байгуулах тухай албан бичгийг аймгийн ОНӨГ-ын ирсэн бичигт хадгалж, заримыг нь тендерийн архивын баримтад үдсэн байна.

1.2. Аймгийн ТЕЗ-ийн хүрээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн ОНӨГ-аас зохион байгуулах ажлын хэмжээнд гаргасан байна.

1.2.1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 264 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.3⁵-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаагүй зөвхөн аймгийн

² "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"

³ "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ"

⁴ "ТЕЗ, төсвийн хүрээний мэдээдлийг үндэслэн аймаг, орон нутгийн хэрэгцээ болон саналыг салбарын бодлоготой уялдуулан, өгөгдсөн санхүүгийн эх үүсвэр, төсвийн хязгаарт багтаан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төслийг боловсруулна"

⁵ "Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг захиалагч нь худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг ...дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор, ... төсвийн ерөнхийлөн захирагч жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх."

ОНӨГ-аар дамжин зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны хэмжээнд төлөвлөгөөг гаргаж хууль, журмыг зөрчжээ.

Аймгийн ОНӨГ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээг нэгтгэж, 2016 онд 4.5 тэрбум төгрөгийн 32, 2017 онд 5.8 тэрбум төгрөгийн 59 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар анх төлөвлөж, аймгийн Засаг даргын захирамжаар төлөвлөгөөг батлуулсан байна.

Оны туршид захиалагч байгууллагуудаас ирүүлсэн тендер зарлах тухай албан бичгийг үндэслэн нэмэлт өөрчлөлтийг тухай бүр оруулж, улирал тутам тодотгосон төлөвлөгөөг Сангийн яаманд хүргүүлж 2016 онд нийт 5.8 тэрбум төгрөгийн 86 тендер, 2017 онд 10.0 тэрбум төгрөгийн 132 тендерийг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Тендерийн хуулийн 48 дугаар зүйлийн 48.3⁶-т заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яаманд, 48.4⁷-т заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хугацаанд нь тус тус хүргүүлжээ.

1.2.2 Худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг орон нутгийн "Баянхонгор таймс" сонинд 2016 оны 01 дүгээр 13-ны өдөр нийтэлж, хуулийг мөрдсөн байна. Харин 2017-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэсний өдөр тутмын "Монголын үнэн" сонинд 2017 оны 04 дүгээр сарын 14-нд буюу 88 хоногийн дараа нийтлүүлэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.5⁸ дахь заалтыг зөрчсөн байна. Хугацаандаа нийтлэгдээгүй шалтгааныг аймгийн ОНӨГ-аас төсөв хүрэлцээгүйн улмаас хойшлогдсон гэсэн тайлбарыг өгөв.

Худалдан авах ажиллагааны холбогдох мэдээллийг 2016 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем www.e-procurement.mof.gov.mn сайтад байршуулан олон нийтэд мэдээлж байжээ. Тухайн цахим систем 2017 оны 04 дүгээр сард өөрчлөгдөж, мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд байршуулж иржээ.

⁶ "Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ"

⁷ "Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ"

⁸ "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ"

Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем өөрчлөгдсөний улмаас 2016 онд байршуулсан худалдан авах ажиллагааны мэдээллийг харах боломжгүй болсон байна.

2017 оны 04 дүгээр сараас хойш www.tender.gov.mn сайтад нийт 223 бараа ажил үйлчилгээний төлөвлөгөө байршуулсны 2 нь "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн, 67 нь Заг, Жаргалант, Баянхонгор, Гурванбулаг, Өлзийт, Шинэжинст сумдын, 154 нь аймгийн ОНӨГ-ын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө байна.

Аймгийн ОНӨГ-ын цахим системд байршуулсан 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тоо нь Сангийн яаманд хүргүүлснээс 22-оор илүү байгаа нь оны эхэнд төлөвлөсөн боловч хэрэгжээгүй 12 төсөл, арга хэмжээ, улсын төсвөөс эрх шилжсэн бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг аймгийн ОНӨГ системд оруулсан байхад яамдаас тэдгээрийг цахим системд оруулсны улмаас давхардсан 11, Баянхонгор сумын ЗДТГ-т эрх шилжүүлсэн 1 арга хэмжээний мэдээлэл хасагдаагүй зэрэгтэй холбоотой байна.

БҮЛЭГ 2.

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1. Үнэлгээний хорооны гишүүнээр АЗ гэрчилгээгүй иргэдийг томилсон, техникийн тодорхойлолтыг зохих шаардлагын дагуу боловсруулаагүй, үнэлгээний хурлын тэмдэглэлд гишүүдийн гарын үсгийг бүрэн зураагүй зэргээр үнэлгээний хороо хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.

2.1.1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.1⁹ дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа урамшууллыг зохицуулах журам"-ын 2.1¹⁰, 2.3¹¹-д заасны дагуу 2016, 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд тендерийн үнэлгээний хороог 5-11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан 115 тендерийн үнэлгээний хороонд захиалагч, мэргэжлийн салбарын төлөөллийг оруулж байгаа боловч гишүүнээр ажилласан

⁹ "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна"

¹⁰ " Үнэлгээний хорооны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Үнэлгээний хороог захиалагчийн шийдвэрээр байгуулна"

¹¹ " Үнэлгээний хороо нь сондгой тооны гишүүдтэй байна"

иргэнийг аймгийн ИТХ-аас томилоогүй, хувийн хэвшлийн төлөөллийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4¹² дэх заалттай нийцэхгүй байна.

Үнэлгээний хороонд ажилласан иргэдийн судалгаанаас харахад цөөхөн тооны иргэдийг оролцуулсан нь хангалтгүй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан иргэдийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээг аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн судалгаа, www.tender.gov.mn сайтын бүртгэлтэй тулган шалгахад 2016 онд давхардсан тоогоор 11 үнэлгээний хороонд ажилласан 2 иргэн, 2017 онд 8 үнэлгээний хороонд ажилласан 4 иргэний гэрчилгээтэй боловч хүчинтэй хугацаа нь дууссан иргэд байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.6¹³ дахь заалтыг зөрчиж байна.

Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон зарим иргэд гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 2.4¹⁴ дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаар тендер зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж материал ирүүлээгүй тендерийн баримт бичигт гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг үнэлгээний хорооны бүх гишүүд гаргаагүй тохиолдлууд нэлээн хэд байгаагаас үзэхэд тухайн иргэнийг хорооны гишүүнээр томилохоос өмнө мэдүүлгийг бичдэггүй, өөрийг нь зөвшөөрөөгүй байхад нь үнэлгээний хорооны гишүүнээр томилж захирамж гаргадаг гэж үзэхээр байна. Зарим тендерийн архивын баримтад үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийн маягыг бөглөөгүй, хоосон маягыг үдсэн байна.

2.1.2. Аймгийн ОНӨГ-аас 2016,2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны баримт бичгийг боловсруулахдаа Сангийн сайдын 2014 оны 212 тоот

¹² " Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна"

¹³ " Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна"

¹⁴ " Үнэлгээний хорооны гишүүд хуульд заасан шаардлагыг хангаж байгаа болон тендерийн үнэлгээний талаарх мэдээлэл, аж ахуй нэгж, байгууллагын нууцыг задруулахгүй байх тухайгаа энэ журмын хавсралт маягтын дагуу гаргаж, баталгаажуулна"

тушаалаар батлагдсан журмын 5.2.1¹⁵ дэх заалтын дагуу тендерийн жишиг баримт бичгийг зөв сонгон ашигласан байна.

Захиалагч байгууллагаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж өгөх тухай албан бичгийг техникийн тодорхойлолттой нь хамт аймгийн ОНӨГ-т ирүүлснийг үндэслэн тендерийн үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 3.1¹⁶ дэх заалтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч аудитын түүвэрт хамрагдсан тендерт дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

➤ *Аймгийн Цагдаагийн газраас 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын албан хэрэгцээнд суудлын автомашин авах тендер зарлах тухай албан бичгийг ирүүлэхдээ техникийн тодорхойлолтод 2010 оноос хойш үйлдвэрлэсэн гэж заасан байхад үнэлгээний хороо тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт боловсруулах хурлыг хийгээгүй атлаа техникийн тодорхойлолтод уг заалтыг 2012 оноос хойш үйлдвэрлэсэн гэж өөрчилсөн. Дээрх зөрчил нь үнэлгээний хорооны боловсруулсан тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулдаггүй, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 3.2¹⁷ дахь заалтыг хэрэгжүүлдэггүйтэй холбоотой байна.*

➤ *Аймгийн ЗДТГ-т суудлын автомашин худалдан авах тендерийн техникийн тодорхойлолтод өнгө зааж оруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3¹⁸ дахь заалтыг зөрчсөн байна.*

➤ *Аймгийн шүүхийн тамгын газар, Цагдаагийн газар, ЗДТГ-т 2017 оны ангилагдаагүй зардлаас орон сууц худалдан авахад тус бүр 52,0 сая төгрөгийн төсвийг баталсан байна. Аймгийн Цагдаагийн газрын орон сууц худалдан авах тендерийн техникийн тодорхойлолтод 2016 онд ашиглалтад орсон 5 давхарт наран талдаа цонхтой, аймгийн ЗДТГ-ын орон сууц худалдан авах тендерийн техникийн тодорхойлолтод 56,08 м2-аас багагүй талбайтай, 2016 онд ашиглалтад орсон, аймгийн Шүүхийн Тамгын газраас 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр ирүүлсэн "Зүүн шанд" ХХК-тай гэрээ байгуулж авсан 2 өрөө орон сууцны санхүүжилтийг шийдэж өгнө үү гэсэн албан бичиг зэргээс харахад орон сууцнуудыг худалдан авсны дараа тендерийг зохион*

¹⁵ " Тендерийн баримт бичиг боловсруулахдаа тухайн бараа, ажил үйлчилгээний онцлогоос хамааруулан, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичгийн аль тохирохыг ашиглах."

¹⁶ " Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт боловсруулахдаа захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, хууль тогтоомжид нийцсэн байх зарчмыг баримтална"

¹⁷ " Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана"

¹⁸ " барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй"

байгуулсан байна. Хууль тогтоомжийг зөрчиж бараа авсны дараа тендерийг зохион байгуулсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Иймд захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, хуульд тогтоомжид нийцсэн байх зарчмыг баримталж, тендерийн баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендерт оролцогчдод тарааж байхыг аймгийн ОНӨГ-т зөвлөв.

2.1.3. Аудитад хамрагдсан 115 худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг боловсруулах хурал, нээлтийн тэмдэглэл, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хурлын тэмдэглэлийг шалгахад үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлүүдийг бүрэн хөтлөөгүй зөрчил илэрлээ.

Он	Аудитад хамрагдсан төсөл арга хэмжээний тоо	Техникийн баримт бичиг, техникийн тодорхойлолт бэлтгэхэд хурлын тэмдэглэл хөтлөөгүй тендерийн		Тендер шалгаруулах хурлын тэмдэглэлд гарын үсэг бүрэн зурж баталгаажуулаагүй тендерийн	
		тоо	хувь	тоо	хувь
2016	44	29	65.9	21	47,7
2017	71	27	38.0	24	33.8
Дүн	115	56		45	

Дээрх хүснэгтээс харахад тендерийн баримт бичиг боловсруулсан хурлын тэмдэглэл байхгүй байгаа нь захиалагч байгууллагаас ирүүлсэн бичиг баримтыг үндэслэн зөвхөн нарийн бичгийн дарга тендерийн баримт бичгийг боловсруулдаг, эсвэл тендерийн үнэлгээний хороо хуралдаагүй, хуралдсан боловч хурлын тэмдэглэлийг хөтлөөгүй байна.

Мөн тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүд гарын үсгээ бүрэн зурж баталгаажуулдаггүй, ирцийн хувийг буруу тооцож гаргасан зэрэг нийтлэг зөрчил ажиглагдаж байгаа нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.8¹⁹, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 4.2²⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь хурлын тэмдэглэлийг дараа нь компьютерт нөхөн бичдэгтэй холбоотой байна. Аудитын явцад хурлын тэмдэглэлд гарын үсэг зураагүй 32 иргэнтэй гар утсаар ярилцлага хийхэд давхардсан тоогоор 6 тендерт оролцсон 2 иргэн “... тендерт

¹⁹ “ Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна”

²⁰ “Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно”

оролцоогүй, сайн санахгүй байна” гэсэн тайлбар өгснөөс харахад ирцийг 75 хувьд хүргэхийн тулд хуралд оролцоогүй иргэнийг байснаар тэмдэглэл хөтөлсөн гэж үзэхээр байна.

2016 онд аймгийн төвийн хатуу хучилттай болон хөрсөн замуудад засвар хийх, 2017 онд аймгийн Цагдаагийн газрын шатахуун, тос, тослогооны материал авах тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл байхгүй, Нийгэм, соёлын салбарын байгууллагуудын автомашин худалдан авах тендерийн үнэлгээний хороонд гишүүнээр томилогдоогүй иргэн үг хэлсэн зэрэг зөрчлүүд нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.7²¹ дахь заалттай нийцэхгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 194 тоот тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын маягт №5-ын дагуу тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн хөтөлж, аймгийн ОНӨГ-ын зарим мэргэжилтнүүд нээлтийн тэмдэглэл боловсруулан хөтөлсөн ололттой тал байна.

2.1.4. Аудитад хамрагдсан 2016 он, 2017 оны эхний 3 сарын тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны хаагдсан цахим системд байршуулсан учир 2017 оны 4 сараас хойших хугацааны тендерийн урилга, үр дүнг аудитаар тулган шалгав.

2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар www.tender.gov.mn сайтаас ТЕЗ-аар мэдээллийг татаж тулгахад аймгийн ОНӨГ тендерийн урилгыг бүрэн байршуулж, харин дараах 5 тендерийн үр дүн харагдахгүй байна.

Гурванбулаг сумын цэвэр усны худгийн барилга, засварын ажлын тендер, Баянхонгор аймгийн ЗДТГ-т орон сууц нийлүүлэх тендер, Номгон ахлах сургуулийн бага ангийн хүүхдийн үдийн цай нийлүүлэх тендер, Бэлчээрийн хортон мэргэчтэй тэмцэх арга хэмжээ авах, Эрдэнэмандал ахлах сургуулийн бага ангийн сурагчдын үдийн цай нийлүүлэх зэрэг 5 тендерийн үр дүнг мэдээлээгүй байна.

²¹ “ Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна”



Үүнийг тодруулахад аймгийн ОНӨГ-ын мэргэжилтнүүдийн цахим системд нэвтрэх эрхээр хандахад тендерийн үр дүнг байршуулсан боловч www.tender.gov.mn сайтад мэдээлээгүй харагдаж байна.

Аймгийн ОНӨГ-аас захиалагч байгууллагуудад цахим системд мэдээлэл тавих эрх олгосны дагуу 2017 онд “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК 2, 6 сумын ЗДТГ-ууд нийт 67 худалдан авах ажиллагааны мэдээллийг сайтад байршуулж байгаа боловч урилга, үр дүнг оруулах ажил хангалтгүй хийгдсэн байна. Иймд цаашид захиалагч байгууллагууд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээллийг бүрэн байршуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлээ.

2.2. Зарим үнэлгээний хороо тендерийг зөв үнэлээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй зэргээр хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

2.2.1. Аудитын явцад хийсэн судалгаанаас харахад 2016 онд зохион байгуулсан нийт тендерийн 46,6% буюу 40 тендер, 2017 онд 48,4% буюу 63 тендерийг төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас өмнө хийсэн байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь төсөвт байгууллагуудын үдийн цай, хоол хүнсний материал нийлүүлэх тендер байна.

Харин 2016 онд зохион байгуулсан нийт тендерийн 28,0% буюу 24 тендер, 2017 онд 38,5% буюу 50 тендерийг төлөвлөсөн хугацаанаас хойш зохион байгуулсан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас хойш зохион байгуулагдсан тендерүүдийн дийлэнх нь барилга барих, засварын ажил байгаагаас Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажил хамгийн их буюу төлөвлөгөөнөөс 43 хоногийн дараа зохион байгуулагдсан байна.

Аудитаар хийсэн судалгаанаас харахад 2016-2017 онуудад зохион байгуулахаар төлөвлөсөн барилга угсралт, засварын ажлуудын 73,3-86,4% нь 4 сараас хойш зарлагдаж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8²² дахь заалтыг мөрдөхгүй

²² " барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх."

байгаагаас улирлын чанартай барилга угсралтын ажлын талбай дээр ажиллах хугацаагүй болж, цаашилбал ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжих боломжгүй байдалд хүргэж байна.

Энэ нь ТЭЗ-д яамдууд эрхээ шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер оройтож зарлагддаг, худалдан авалтын төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөвгүй ажлыг тусгаж, аймгийн ОНӨГ-аас ТЭЗҮ, зураг төсөв, техникийн тодорхойлолтыг бэлэн болсны дараа тендерийг зарладаг, оны дундуур төсөвт тодотгол хийдэг зэрэгтэй холбоотой байна.

Иймд цаашид төсвийн төсөл хийгдэх хугацаанд ТЭЗҮ, зураг төсвийг бэлтгэж, магадлангаар хянуулан дүгнэлт гаргуулан төлөвлөгөөнд тусгаж, тендерийг эхний улиралд багтаан зохион байгуулж байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Аудитын явцад төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан эсэхийг судлахад дараах байдалтай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас	2016 он		2017 он	
	тендерийн тоо	хувь	тендерийн тоо	хувь
Хугацаандаа хийгдсэн	22	25.6	17	13.1
31-ээс дээш хоногийн өмнө хийгдсэн	4	4.7	6	4.6
30 хоногийн өмнө хийгдсэн	36	41.9	57	43.8
30 хоног хэтэрсэн	20	23.3	39	30.0
31-ээс дээш хоног хэтэрсэн	4	4.7	11	8.5
Нийт дүн	86	100	130	100

Худалдан авах ажиллагааны цахим нэгдсэн системийг нэвтрүүлэн худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зарлах тухай Засгийн газрын 2017 оны 17 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг хангалтгүй биелүүлж, 2017 оны 130 тендерээс 16 тендерийг цахимаар мэдээлсэн тул цаашид худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн ОНӨГ-т зөвлөв.

2.2.2. Аудитын түүвэрт хамрагдсан 2016 оны 44, 2017 оны 71, нийт 115 худалдан авах ажиллагаанаас 18 тендерийг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулжээ. Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан аймгийн ОНӨГ-ын мэргэжилтнүүдийн зохион байгуулсан тендерийг судалгаагаар гаргахад дараах байдалтай байна.

№	Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын нэр	2016 оны түүвэрт хамрагдсан тендерийн тоо	2017 оны түүвэрт хамрагдсан тендерийн тоо	Нийт зохион байгуулсан тендерийн тоо	Үүнээс хуулийн дагуу зохион байгуулсан тендерийн тоо	Хуулийн дагуу зохион байгуулсан тендерийн хувь хэмжээ

1	Б.Цэрэнлхагва	14	13	27	4	14.8
2	Н.Энх-Амгалан	16	25	41	2	4.9
3	С.Рэнцэнбямба	14	16	30	2	6.7
4	Р.Янжмаа		8	8	6	75.0
5	Ч.Үйтүмэн		2	2	0	0.0
6	Л.Доржханд		6	6	3	50.0
7	М.Пүрэвдулам		1	1	1	100.0
	Нийт	44	71	115	18	

Аудитаар 2016 онд 345,1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 тендер, 2017 онд 1174,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 тендерийг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмыг мөрдөөгүйгээс тендерийн бичиг баримтыг зөв үнэлж, хянаагүй алдаа илэрлээ. Үүнд:

2016 онд:

- Хот тохижилт үйлчилгээний газарт гэрэлтүүлгийн засварын автокран худалдан авах тендерт 2014, 2015 онд ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх гэж заасан байхад ижил төстэй ажил гүйцэтгээгүй “Оточ Царам дринллинг” ХХК-ийг шалгаруулсан;
- Аймгийн Цагдаагийн газрын албан хэрэгцээнд 60,0 сая төгрөгийн суудлын автомашин авах тендерт нэг ч материал ирүүлээгүй байхад үнэлгээний хорооны гишүүдийн олонхийн саналаар шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1²³ дэх заалтыг зөрчсөн;
- Өвс тэжээл нийлүүлэх 100,0 сая төгрөгийн тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх заалтын дагуу нээлттэй тендер шалгаруулалтыг дахин явуулах байтал шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн;
- 2016 онд Баянхонгор сумын 2-р цэцэрлэгт хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх тендерийн хүнсний ногоо жимс жимсгэний багцад “Хөшөөт арвижих далай” ХХК 6506,8 мянган төгрөг буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн байтал 7209,8 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Далай ээж Баянхонгор” ХХК-ийг шалгаруулсан байна.
- Баянхонгор сумын 6-р цэцэрлэгт хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх тендерийн 4-р багц буюу хүнсний ногоо нийлүүлэх тендерт “Хөшөөт арвижих” ХХК ерөнхий шаардлага хангаагүй байхад үнэлж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн гэж шалгаруулсан байна. Энэ багцад “Софтвишн” ХХК нь ерөнхий шаардлагыг хангаж байна.
- Баян-Ойт цогцолбор сургуулийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх тендерийн үнэлгээний хороо 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ба тендер шалгаруулах хуралд 71,4% буюу 5 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдсан байхад хурлын тэмдэглэлд 80%-ийн

²³ “ тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;”

ирцтэйгээр тэмдэглэж, шалгаруулалтыг хийсэн нь Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 4.2²⁴ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2017 онд:

➤ Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засварын 70000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгээчийг шалгаруулах анхны тендерт “Эх бүрдэн” ХХК 60588,7 мянган төгрөгөөр шалгарсан байна. Тус тендерт 59350,9 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн “БДЗ” ХХК-ийн түргэн хөрвөх чадвартай хөрөнгөнд тухайн компанийн захирлын нэр дээрх хадгаламжийг тооцоогүйн улмаас Сангийн яаманд гомдол гаргахад тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй байна гэж хянажээ. Үнэлгээний хороо анх тендерийг зөв үнэлсэн бол дахин тендер зарлалгүй, төсөвт 8281,3 мянган төгрөгийн тендерийн хэмнэлт бий болох боломжтой байжээ. Учир нь анхны тендерт “Эх бүрдэн” ХХК 8 хувийн үнийн хөнгөлөлт тооцож, 60588,7 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн, тендерийг дахин зарлахад “Эх бүрдэн” ХХК-аас өөр аж ахуйн нэгж оролцоогүй, тухайн компани 68869,9 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан байна.

➤ Аймгийн ЗДТГ-ын цэцэрлэг байгуулах гүйцэтгээчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан “Елбата” ХХК-ийн ирүүлсэн материалд инженер техникийн ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар байхгүй, Налайх дүүргийн иргэний нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлсэн, өмнөх жилд байгуулж, хугацаа дууссан автомашин түрээслэх гэрээг ирүүлсэн байхад шалгаруулсан;

➤ “Чандмань Баянхонгор” ХК-ийн конторын барилга, цэцэрлэг барих тендерийн үнэлгээний хороог 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдөр байгуулж, нээлттэй тендер сонгон шалгаруулалтад “Хаш гоёо” ХХК материал ирүүлснийг үнэлгээний хороо 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж, тус компанийг шалгаруулж, аймгийн Засаг даргад гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлжээ. Шалгарсан компанид аймгийн Засаг даргаас 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн байхад тус аж ахуйн нэгжтэй тендер сонгон шалгаруулалт явуулахаас өмнө буюу 2017 оны 07 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29.2²⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

➤ Баянхонгор суманд баригдах хуримын ордны барилгын ажлын зураг төсөө боловсруулах тендерийн техникийн тодорхойлолтод сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын жагсаалтыг холбогдох баримтын хуулбарын хамт ирүүлэхийг заасан байхад 2015 онд байгуулагдаж, 2016 онд тусгай зөвшөөрлөө авсан, өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгээгүй “Урбан девелопмент консалтинг” ХХК-ийг шалгаруулсан;

²⁴ " Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно"

²⁵ " Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдээдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна"

- *Бөмбөгөр суманд Спорт цогцолбор барих тендерт техникийн тодорхойлолтод заасан 3 ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар байхгүй, Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газраас гэрээний үүргээ зөрчсөний улмаас иргэдтэй маргаан үүсч, эвлэрлийн гэрээ байгуулсан тухай тодорхойлолтыг ирүүлсэн байхад “Халзан хайрхан” ХХК-ийг шалгаруулсан;*
- *Аймгийн БСУГ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн баримт бичгийг шалгахад шалгарсан компани болох “Баялаг ундарга” ХХК нь ТӨӨЗ-ийн 1.1 дэх заалт буюу 2015, 2016 оны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл, борлуулалтын хэмжээ, удирдах ажилтны танилцуулга зэрэг шаардлагуудыг хангаагүй байна.*
- *12, 17-р байрнуудын гадна пасад, орц, бохирын шугамын засварын ажлын тендерийн баримт бичгийг шалгахад үе ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан “Хүрэн жинсний овоо” ХХК нь ТӨӨЗ-д заасны дагуу инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлээгүй, мөн ТӨӨЗ-ийн 5.3 в-д заасан ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэж, гэрээ болон хүлээлгэн өгсөн комиссын актыг хавсаргана гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27, 28 дугаар зүйлийн 27.1²⁶, 28.1²⁷ дэх заалтуудыг зөрчсөн байна.*

ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зөв хянаж, үнэлээгүй дээрх 13 тендерийн хорооны гишүүнээр ажилласан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн Цагдаагийн газраас өмнөх жилүүдэд баригдсан сумдын цагдаагийн кубоны чанар, өнөөгийн байдлын талаар тодорхойлолтуудыг сумдаас гаргуулж, Жинст, Шаргалжуут тосгоны цагдаагийн кубоны тендерийг үнэлэхэд тодорхойлолтуудыг тооцож хянасан нь сайн талтай байна. Харин бусад тендерийн хувьд өмнөх онуудад ижил төстэй гүйцэтгэсэн ажлын талаар тендерт оролцогч компаниудын туршлагын талаар мэдээлэл авч байгаа боловч зөвхөн ажил гүйцэтгэх гэрээ, ажлыг хийж гүйцэтгэсэн болно гэсэн өмнөх онуудын албан бичгээр хязгаарлагдаж байна. Тендерийг үнэлэхдээ аж ахуйн нэгжүүдийн өмнө гүйцэтгэсэн ажлын чанар байдлын талаарх ашиглагч байгууллагуудын тодорхойлолтыг харгалзан үзэх шаардлагатай байна. Ингэснээр ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, хөрөнгө оруулалтын үр өгөөж сайжрах үр дүн гарна.

²⁶ " Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ:"

²⁷ " Нэг үе шаттай тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хянаж, шаардлагад нийцсэн гэж үзсэн бүх тендерт үнэлгээ хийнэ"

Аудитаар илэрсэн зөрчлөөс үзэхэд тендер зарлахдаа үнийн судалгаа хийдэггүй, тендерийн үнэнд мэргэжлийн байгууллага болох аймгийн ОНӨГ хяналт тавиагүй, суудлын автомашин урьдчилан бэлдээд, тендерийг амжилтгүй болсны дараа техникийн тодорхойлолтод нийцэхгүй хөрөнгө бэлтгэж байгаагаас харахад ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй байдал ажиглагдаж байна.

2.2.3. Аудитын түүвэрт хамрагдсан 115 тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5²⁸ дахь заалтын дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанд зохион байгуулсан байна.

2.2.4. Аймгийн ОНӨГ-аар худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, шалгарсан аж ахуй нэгжтэй аймгийн Засаг дарга, захиалагчийн талыг төлөөлж аймгийн ОНӨГ-ын дарга, захиалагч байгууллагын удирдлагатай гэрээ байгуулж, Хууль эрх зүйн хэлтсийн даргаар хянуулсан байна.

Харин шууд гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу байгуулсан гэрээнд аймгийн Засаг дарга, захиалагчийн талыг төлөөлж ХОХБТХэлтсийн дарга, захиалагч байгууллагын удирдлагатай гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6²⁹ дахь заалтын дагуу аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд ХОХБТХэлтэс чиг үүргийн дагуу хяналт тавих үүрэгтэй боловч зөвхөн тус хэлтсийн даргатай байгуулсан гэрээнд хяналт тавьж, захиалагчийн талыг төлөөлж аймгийн ОНӨГ-ын даргатай байгуулсан гэрээнд хяналт тавьдаггүй, аймгийн ОНӨГ-аас гэрээний хэрэгжилтэд хяналт огт хийдэггүй байна.

Үнэлгээний хороо байгуулсан аймгийн Засаг даргын 2017 оны захирамжуудад “Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д даалгасугай” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тендер амжилтгүй болсны улмаас захиалагч байгууллагад хүргүүлсэн гэрээ шууд байгуулах зөвлөмжид гэрээ байгуулахдаа аймгийн ОНӨГ-аар хянуулж байх гэж оруулсан боловч архивын баримтад байгуулсан гэрээ, гэрээний биелэлтийг илтгэх баримт материал байхгүй байна. Аудитын түүвэрт хамрагдсан шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн ажлуудын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг захиалагч байгууллагуудаас татаж шалгахад:

➤ *Заг суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт тус сумын харьяат “Буянт нар Уул” ХХК оролцохдоо үнийн санал ирүүлээгүй ба*

²⁸ " Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна”

²⁹ " бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”

үнэлгээний хорооны гишүүд шаардлага хангаагүй гэж үзэж, шууд гэрээ байгуулах зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлсэн байна. Сумын Засаг даргын 2016 оны 26 тоот захирамжаар хүнсний эрхийн бичгээр иргэдэд үйлчлэх ажлыг тендерт шалгараагүй “Буянт нар Уул” ХХК-тай байгуулах захирамжийг гаргаж гэрээ байгуулсан ба гэрээний дүнг гэрээнд тусгаагүй.

➤ Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хүнсний материал нийлүүлэх тендерийг 4 багцаар зарлахад 8 аж ахуйн нэгж материал ирүүлснээс бүх тендерээс татгалзаж, шууд гэрээ байгуулахыг зөвлөжээ. Үүний дагуу гэрээ байгуулахдаа тус тендерт оролцсон 4 ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан ба 18816,7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй гурил, гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх багцад “Шижир титэм” ХХК нь 15666,4 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн байхад тендерээс бий болох 3150,3 мянган төгрөгийн хэмнэлтийг тооцолгүй, төсөвт өртгөөр тухайн компанитай гэрээ байгуулж, төсөв хэмнэх боломжийг алдсан байна.

Иймээс цаашид аймгийн ОНӨГ, ХОХБТХ-ийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг гэрээнд тодорхой тусгаж, ажлын чанар, хугацаа мөрдөлтөд анхаарч, ТБОНӨХБАҮХАТ хууль, холбогдох журмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2012 оны 264 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.3³⁰ дахь заалтыг хэрэгжүүлж, захиалагч байгууллагуудаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг гаргуулаагүй зөрчилтэй байна. Иймд цаашид захиалагч байгууллагуудаас тайланг бүрэн авч нэгтгэж байхыг аймгийн ОНӨГ-т зөвлөв.

БҮЛЭГ 3.

Аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланд захиалагч байгууллагуудын тайланг нэгтгэж гаргаагүй байна.

3.1. Захиалагч байгууллагууд хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааны тайланг аймгийн ОНӨГ-т ирүүлээгүй байна.

3.1.1. ХОХБТХэлтэс, захиалагч байгууллагуудаас тухайн жилийн худалдан авалтын тайланг аймгийн ОНӨГ-т ирүүлээгүй, сумдын ЗДТГ-ууд хугацаа хоцроож ирүүлэхдээ батлагдсан маягтаар гаргаагүй зэргээр ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5³¹ дахь заалтыг зөрчсөн байна.

³⁰ " Захиалагч тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр маягт№3-ын дагуу бэлтгэж,...холбогдох тайлбар тодруулыг тодорхой тусгана.."

³¹ " Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана"

Иймд цаашид аймгийн ОНӨГ-аас захиалагч байгууллагуудыг тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах арга зүйгээр хангах ажиллах шаардлагатай байна.

3.1.2. Тайлант оны ТЕЗ-ийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланд аймгийн ОНӨГ, сумдын ЗДТГ, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, бусад захиалагч байгууллагуудын худалдан авалтын тайлан нэгтгэгдэж тайлагнах байтал аймгийн ОНӨГ зөвхөн өөрийн байгууллагаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сумдаас хугацаа хоцроож ирүүлсэн тайланг аймгийн ОНӨГ нэгтгэж, Сангийн яаманд цахимаар хүргүүлж мэдээлсэн байна. Иймд захиалагч байгууллагуудаас ирүүлсэн худалдан авалтын тайланг бүрэн нэгтгэж, хуульд заасан хугацаанд холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг аймгийн ОНӨГ-т зөвлөлөө.

Худалдан авах ажиллагааны 2016 жилийн эцсийн тайланг Сангийн сайдын 2012 оны 264, 2016 жилийн эцсийн тайланг 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын маягтаар гаргасан байна.

2017 онд шинээр батлагдсан тоот журмын маягт 7-оор ТЕЗ-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг гаргаагүй, зарим тендерийн үнэлгээний хороо байгуулсан огноо, гүйцэтгэгчийн нэрийг буруу тайлагнасан, тайланг Сангийн яаманд хугацаа хоцроож хүргүүлсэн нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 49.5³² дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд батлагдсан маягтын дагуу тайланг иж бүрэн, үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлж байхыг аймгийн ОНӨГ-т зөвлөж байна.

3.1.3. Сангийн сайдын 2012 оны 264 тоот тушаалаар батлагдсан журмын дөрөвт заасан шалгуурын дагуу Сангийн яамнаас 2016 оны ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны үнэлгээг хийж, төлөвлөгөөний төслийг цаг хугацаанд нь ирүүлээгүй, тендер шалгаруулалтын явц, үр дүнг тухай бүр оруулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бүх үйл ажиллагаа цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй, тендерийн үр дүнг мэдээлээгүй зөрчил гаргасны улмаас 68 хувьтай дүгнэсэн байна.

2017 оны 12 дугаар сард батлагдсан Сангийн сайдын 363 тоот тушаалаар ТЕЗ-чдын худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 6 ТЕЗ

³² " Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана"

"маш сайн" гэж үнэлэгджээ. Харин манай аймгийн ТЕЗ-ийн хувьд худалдан авах ажиллагааны тайланг цаг хугацаанд нь бүрэн гаргаж хүргүүлээгүй, цахимаар тендер зарласан байдал хангалтгүй, захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гарсан гомдлын тоо олон, ТЕЗ-ийн харьяа байгууллага, сумдын тайланг нэгтгэж ирүүлээгүй зэрэг ажлыг дутуу гүйцэтгэсэн гэж Сангийн яам 71,3 хувьтай үнэлэгджээ.

3.2. Худалдан авах ажиллагаа бүрд архивын нэгж үүсгэн хадгалсан тендерийн хавтаст хэрэгт хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй байна.

3.2.1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1³³-д заасны дагуу зохион байгуулсан худалдан авах ажиллагаа бүрт архивын нэгж болгон хадгалсан боловч зарим ажлын зураг төсөв, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн тендерийн материалыг архивын нэгж болгон хадгалаагүй байна.

3.2.2. Тендерийн хавтаст хэрэгт ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар нийт 10-н нэр төрлийн баримт бичгээс бүрдэхээр заасан байхад ихэнх архивын баримтад худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээг дүгнэж бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан тухай баримт бичгийг хавсаргаагүй нийтлэг алдаа зөрчил илэрлээ.

Иймд худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер оролцогчдын ирүүлсэн баримт материал, ажлын зураг төсөв, гишүүдийн АЗ гэрчилгээ болон тухайн тендерийг зохион байгуулахтай холбоотой хууль, журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж ажиллахыг аймгийн ОНӨГ-т зөвлөв.

Аудитаар 1675,9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, хууль тогтоомжийг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

³³ "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална"

Холбогдох байгууллагуудын санал

Тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, ОНӨГ, ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэхэд саналгүй гэсэн хариу ирүүлсэн. Байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хавсаргав.


**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**
64101 Номгон, Баянхонгор сум
Утас/ факс 70-44-41-41, 70-44-32-24

2018.06.19 № А/186

танай _____-ны № _____ Т

Г Нийцлийн аудитын тайлангийн _____ Т
төсөлтэй танилцсан тухай

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Б.Додинжав
Агуйн ажилтан
6/5

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 оны 05 дугаар сарын 11-нээс 06 дугаар сарын 13-ны өдөр хүртлэх хугацаанд 2016-2017 онуудад худалдан авах ажиллагаагаар зохион байгуулагдсан төсөл арга хэмжээнээс түүвэрлэн нийцлийн аудитыг хийсэн.

Тус нийцлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Манай байгууллагын зүгээс тайлангийн төсөлд тусгагдсан алдаа дутагдалыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд цаашид тус зөвлөмжинд тусгагдсан санал дүгнэлтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тусгаж, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдэд үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг ханган биелүүлж ажиллах болно.

ДАРГА



Ц.ИДЭРМӨНХ

2518010

D:\2018 on\2018 toot A4\toot A4 2018.docx



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум
<http://www.bayankhongor.gov.mn>
Утас, Факс 70-44-22-73

2018.06.19 № 7/855

танай 2018.06.18-ны № 1/71 Т

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г
АУДИТЫН ГАЗАРТ

"2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх"-д хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Манай хэлтсээс тус тайлантай холбоотой санал байхгүй болно

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ИХБАЯР



Б. Доржиев
Аудитын газар

1181074

D:\2018 он\Тамгын газар\Тамгын газар А5 тоот.docx

Нийцлийн аудитын тайлан
НАГ-БНАТАГ-/2018/-02-НА

"2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх"

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Худалдан авах арга хэмжээний төлөвлөгөөнд Төсвийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг баталсан байна.
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байна.
3. Ажил нь эхэлсэн, бараа худалдан авсны дараа хууль зөрчиж тендерийг зохион байгуулсан байна.
4. Тендерийн үнэлгээний хороо хууль журмыг зөрчиж, зарим тендерийг зөв хянаж, үнэлээгүй ажлын хариуцлага алдсан байна.
5. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хуульд заасан төлөөллийг томилоогүй, томилогдсон гишүүд мэдүүлэг, мэдэгдлийг гаргаагүй, хурлын тэмдэглэлд гарын үсэг бүрэн зураагүй, тендерийн техникийн тодорхойлолтыг зохих шаардлагын дагуу боловсруулаагүй зэргээр ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлд заасныг мөрдөж ажиллаагүй байна.
6. Аудитын түүвэрт хамрагдсан улирлын шинж чанартай зарим ажлуудыг төсөв батлагдсан даруйд эхлүүлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байна.
7. Захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хуульд заасан хугацаанд аймгийн ОНӨГ-т ирүүлээгүйгээс аймгийн ТЕЗ-ийн төлөвлөгөө, тайланд нэгтгэгдээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48.4, 49.5 дахь заалтыг зөрчсөн байна.
8. Захиалагч тал нь аймгийн ХОХБТХ байхад аймгийн ОНӨГ нь захиалагчийг төлөөлж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан атлаа гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавиагүй байна.
9. Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа бүрд архивын нэгж болгон хадгалсан тендерийн хавтаст хэрэгт хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа:

1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 3.7 дахь заалтыг мөрдөж, ТЭЗҮ, зураг төсвийг бэлтгэж, магадлангаар хянуулсан төсөл, арга хэмжээг батлах.
2. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.6 дахь заалтыг хэрэгжүүлж, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн АЗ гэрчилгээтэй иргэнийг томилж байх.

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа:

1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 3.7 дахь заалтыг мөрдөж, ТЭЗҮ, зураг төсвийг бэлтгэж, магадлангаар хянуулсан төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байх.
2. Захиалагч байгууллагыг төлөөлж ХОХБТХ гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, гэрээнд ажил гүйцэтгэх хугацаа, хяналтын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой зааж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх танаа

1. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар батлагдсан боловч ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгахгүй байх.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг улс, орон нутгийн төсөв батлагдсаны дараа хуульд заасан хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж, мэдээллийн шуурхай байдлыг хангаж ажиллах.
3. Төсөл арга хэмжээ хэрэгжсэн эсвэл эхэлсний дараа тендерийг зохион байгуулдаг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох.

Нийцлийн аудитын тайлан
НАГ-БНАТАГ-/2018/-02-НА

"2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх"

- Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо худалдан авах ажиллагааны гэрчилгээний хүчинтэй хугацааг харгалзаж, үнэлгээний хорооны гишүүд хууль, журамд заасан үүргээ бүрэн биелүүлж ажиллаж байгаад хяналт тавьж ажиллах.
- Тодорхой улиралд гүйцэтгэх, онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй оны эхний улиралд багтаан гэрээ байгуулж, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
- Аймгийн ТЕЗ-ийн төлөвлөгөө, тайланд захиалагч байгууллагуудын төлөвлөгөө, тайланг тусгаж холбогдох байгууллагуудад заасан хугацаанд хүргүүлж байх.
- ТБОНӨХБАҮХАТ хуульд заасан баримтууд болон захиалагч байгууллагаас ирүүлсэн албан бичиг, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, АЗ гэрчилгээ болон хуульд заасан баримт бичгийг тендерийн хавтаст хэрэгт бүрэн бүрдүүлж байх.

**Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн
дарга Д.Ихбаяр танаа**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийн шатанд хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон судалгаа, баримт материал, ТЭЗҮ, зураг төсвийг архивын нэгж болгон хадгалах.
- Гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, худалдан авах ажиллагааны тайланг хууль, журамд заасан хугацаанд аймгийн ОНӨГ-т хүргүүлж ажиллах.

Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 10 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 29

Номгон

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.1, 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Должмаа, аудитор П.Мөнх-Эрдэнэ, аудитор Б.Нарангэрэл нарт даалгасугай.

ДАРГА

Б. МӨНХБАТ

2517128

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны 06 дугаар
сарын 20-ны өдрийн 29 тоот тушаалын хавсралт

2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх

/сая төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Акт албан шаардлагын дугаар	Нийт зөрчлийн дүн	үүнээс	
				Акт	Албан шаардлага
1	Зарим үнэлгээний хороо тендэрт ирүүлсэн баримт бичгийг үнэлж шалгаруулахдаа холбогдох хууль, журмыг мөрдөөгүйгээс 2016 онд 6, 2017 онд 7 тендерийн бичиг баримтыг зөв үнэлж, хянаагүй байна.		1519.9		1519.9
2	Захиалагч байгууллагаас ирүүлсэн албан бичиг, техникийн тодорхойлолт, ажлын даалгаварыг үндэслэн тендерийн баримт бичиг боловсруулахдаа зарим тендерийн техникийн тодорхойлолтыг алдаатай боловсруулсан байна. Барааг худалдан авсны дараа тухайн бараанд тохирсон техникийн тодорхойлолт боловсруулж, хууль, тогтоомжийг зөрчиж тендерийг зохион байгуулсан байна.		156.0		156.0
	ДҮН		1675.9		1675.9